



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Инженерийн баг, хяналтын инженер  
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигацийн бодлого зохицуулалтын газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан “Холбоо, навигаци, ажиглалтын албаны үйл ажиллагааны заавар”-ын 6.2, Байгууламжийг суурилуулах ба ажилд хүлээн авах журмын 6.2.3, 6.2.5.1, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ИНЕГ/ХО/ТББ/Б-34/20 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн Нисэхийн суурин холбооны AFTN системийн серверүүд болон холболтын тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг хавсралтаар томилсугай.

2. Суурилуулалтын ажлыг агаарын навигацийн байгууламжуудын хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүйгээр нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангахаар зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөж ажиллахыг инженерийн багийн ахлагч /Г.Нандин-Эрдэнэ/-д, суурилуулалтын ажилд хяналт тавьж ажиллахыг хяналтын инженер /Э.Булган/-т тус тус үүрэг болгосугай.

3. Суурилуулалтын ажлын явц болон гүйцэтгэлийг цаг хугацаанд нь батлагдсан төлөвлөгөөний дагуу чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба /М.Эрдэнэсүх/-нд үүрэг болгосугай.


ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0076

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2021 оны 01 дүгээр сарын 22 -ны өдрийн  
А/10 дугаар тушаалын хавсралт



Нисэхийн суурин холбооны AFTN системийн серверүүд болон  
холболтын тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах ажлыг хийж гүйцэтгэх  
инженерийн баг, хяналтын инженер

Инженерийн багийн ахлагч:

Г. Нандин-Эрдэнэ

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Холбооны хэсгийн Өгөгдлийн холбооны  
тасгийн ахлагч инженер

Гишүүд:

Т.Сутай

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Холбооны хэсгийн Өгөгдлийн холбооны  
тасгийн ахлах инженер

Э.Энхболд

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Холбооны хэсгийн Өгөгдлийн холбооны  
тасгийн инженер

Б.Наранмандах

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Тоног төхөөрөмж инженерингийн хэсгийн  
технологич инженер

Хяналтын инженер:

Э.Булган

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Холбооны хэсгийн дарга

-----oOo-----